

Contents

- 2 日本語版
- 4 Bản tiếng Việt [ベトナム語版]
- 6 中文版 [中国語版]
- 8 Bersyon sa Pilipino [フィリピン語版]
- 10 Edisi Bahasa Indonesia [インドネシア語版]
- 12 ฉบับภาษาไทย [タイ語版]
- 14 ភាសាខ្មែរ [カンボジア語版]
- 16 မြန်မာဘာသာ မူ [ミャンマー語版]
- 18 Монгол хэл дээрх хувилбар [モンゴル語版]
- 20 English Version [英語版]

こくごのもり

小学低学年の児童を対象に国語の楽しさを知ってもらおうと、イラストを多用してつくった問題で「毎日小学生新聞」に長期連載。

©毎日小学生新聞 複製、転用はできません

表の数字と合う字を、□に書きましょう。

あいうえおのひょう

指導・元世田谷区立
小学校教諭
高橋 侖子
イラスト・奈良 恵

答えはP22にあります。

Ур чадварын дадлагажигчийн анд нөхөр

2019 оны 7 дугаар сар, Зуны улирлын дугаар

Шинэ он тооллын нэр “Рэйва”

Энэ он (2019 он)-ы 5 дугаар сарын 1-ний өдрөөс, Японд эзэн хааны үе солигдож, үүнтэй зэрэгцэн он тооллын нэр нь “Хэйсэй”-ээс “Рэйва” болж өөрчлөгдсөн. Он тооллын нэр гэдэг нь он (он цаг)-д өгөгдөх нэр бөгөөд Японы он тооллын нэрийн тухай, 1979 оны “Он тооллын нэрийн тухай хууль”-д “Зөвхөн эзэн хааны суудал үе уламжлагдсан үед л өөрчилнө”. хэмээн заагдсан байдаг ба үүнийг “Он тооллын нэрийг өөрчлөх” гэж хэлдэг. Энэ он нь “Рэйвагийн анхдугаар он” болно. Рэйвагийн өмнөх Хэйсэй-ийн үе нь 31 жил үргэлжилсэн тул, 2019 он нь, 4 дүгээр сарын 30-ны өдөр хүртэлх нь “Хэйсэй-ийн 31 он” болох ба 5 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн “Рэйвагийн 1 он” болно.

Он тооллын нэр нь улс орны хүсэн тэмүүлж буй дүр төрхийг илэрхийлдэг ба “Рэйва”-ийн “Рэй” гэдэг нь “Гайхалтай”, “Ва” гэдэг нь “зохицол” гэдгийг илэрхийлнэ. Эх сурвалж нь, одоогоос ойролцоогоор 1250 жилийн өмнөх үеийн Японы хамгийн эртний дууны цомог “Ман-ёошюу”.

Он тооллын нэр нь Хятад болон Вьетнамд ч хэрэглэгдэж байсан боловч, аль аль нь сүүлийн үед устаж үгүй болсон ба одоо зөвхөн Японд л хэрэглэгдэж байна. Он тооллын нэрийг хэрэглэсэн он тооллыг “Варэки буюу Японы он тоолол” гэж хэлдэг ба одоо үед европын он тоолоор он цагийг илэрхийлэх тохиолдол их болж, Япон хүмүүс ч өөрсдөө варэки буюу Японы он тоолол болон европын он тооллыг зэрэгцүүлсэн мэдээллийг интернетээр шалгах тохиолдол их гардаг.

Он тооллын нэрний талаар бяцхан мэдлэг

Хэйсэй-ийн анхдугаар он (Н1) нь европын он тооллын 1989 он. Мөн, он тооллын нэрийг товчилж бичихдээ “Н1” гэх мэтээр Ром үсгийг хэрэглэх тохиолдол их байдаг. “Хэйсэй”-ийн эх сурвалж нь, Хятадын “Эртний Хятадын түүхэн тэмдэглэл”, “Эртний Хятадын түүхийн судар”. Утга нь, “Гадаад, дотоод, тэнгэр, газаргүй энх тайван биеллээ олох”.

Хэйсэй-ийн өмнөх он тооллын нэр нь “Шоова”. Шоовагийн анхдугаар он (S1) нь европын он тооллын 1926 он. “Шоова”-гийн эх сурвалж нь, Хятадын “Эртний Хятадын түүхийн судар”. Утга нь, “Ард иргэдийн энх тайван болон дэлхий нийтээр зэрэгцэн оршиж, хамтдаа хөгжиж цэцэглэх”.

Турphoon буюу хар салхи дайрах үед бэлтгэлтэй байцгаая

“Турphoon буюу хар салхи” гэдэг нь, зүүн ази орчмын Номхон далайгаар, маш эрчимтэйгээр шилжин нүүдэг халуун орны циклоныг хэлдэг. Жил бүрийн 7 дугаар сараас 9 дүгээр сар хүртэлх үед, турphoon буюу хар салхи Японы арал руу ойртон ирж, Японы арлыг дайрдаг ба, үүнээс улбаатайгаар, их хэмжээний бороо орох, хүчтэй салхи салхилах, гол мөрний ус эргээсээ хальж гарах, хөрсний гулгалт бий болох, тог тасрах, ус тасрах гэх мэт үзэгдлүүд гардаг. 2018 онд, ердийн жилүүдээс илүү олон удаа, 29 удаа турphoon буюу хар салхи гарч, үүний 21 удаа нь Японы арал руу ойртон ирж, Японы арлыг дайрсан ба хүний амь нэрвэгдэж, хүн гэмтэж бэртсэн их хэмжээний хохирол учруулсан.

Турphoon буюу хар салхи нь, газар хөдлөлттэй адилгүй, урьдчилан мэдээлэл цуглуулах боломжтой учраас, телевиз болон радио, интернет зэргийг ашиглан, хамгийн шинэ “Гамшгаас сэргийлэх цаг уурын мэдээ”-г олж, бэлтгэлээ базаацгаая. Ердийн үед ч, байгалийн гамшиг гарсан үед хэрхэн арга хэмжээ авах талаар мэдэж авч хэвших нь мөн ач тустай байдаг. “Ур чадварын дадлагажигчийн анд нөхөр”-ийн 2018 оны 10 дугаар сарын дугаараар, орон нутгийн захиргааны байгууллагуудаас гаргаж буй гадаадын иргэдэд зориулсан гамшгаас сэргийлэхтэй холбогдох хэд хэдэн цахим хуудсыг танилцуулсан. (“Technical Intern Trainees' Mate”-ийн цахим хувилбар <https://www.jitco.or.jp/webtomo/>-аас мөн харах боломжтой.) Дараах цахим хуудсуудыг шинээр танилцуулж байна.

[Гамшгаас сэргийлэхтэй холбогдох олон орны хэл дээрх цахим хуудсуудын танилцуулга (2019 он)]

- 🌐 “Safety tips” (Гадаадын жуулчдад зориулсан гамшигын үед мэдээлэл олгох аппликэйшн [Англи хэл, Хятад хэл (Хялбаршуулсан ханз / Хялбаршуулаагүй ханз), Солонгос хэл, Япон хэл]) Аялал жуулчлалын агентлагаас гаргасан.
Android: <https://play.google.com/store/apps/details?id=jp.co.rcsc.safety.tips>.android
iPhone: <https://itunes.apple.com/jp/app/safety-tips/id858357174?mt=8>
- 🌐 “Оршин суугч гадаадын иргэдэд зориулсан гамшгаас урьдчилан сэргийлэх гарын авлага” (Анхан шатны Япон хэл, Вьетнам хэл, Хятад хэл, Тагалоог хэл, Индонези хэл зэрэг) Кагава мужаас гаргасан.
https://www.pref.kagawa.lg.jp/content/etc/subsite/kokusai/live_together/m_disaster/guidebook.shtml
- 🌐 “The Disaster Prevention Handbook” (Вьетнам хэл, Хятад хэл, Тагалоог хэл зэрэг) Фүкү-ока мужаас гаргасан.
<https://www.bousai.pref.fukuoka.jp/foreigners/detail/5>
- 🌐 “Гамшгийн үеийн зааварчилгаа” (Ханзны дуудлагыг нь хадсан Япон хэл, Вьетнам хэл, Хятад хэл, Тагалоог хэл, Индонези хэл, Тайланд хэл зэрэг) (Олон нийтийн эрх ашгийн төлөөх байгууллага) Ибараки мужийн олон улсын харилцааны нийгэмлэгээс гаргасан.
<https://www.ia-ibaraki.or.jp/kokusai/soudan/disaster/>



Хар салхины мэдээллийг харуулсан жишээ (Японы Цаг уурын албаны вэбсайтаас)

Дулааны цохилтонд өртөхөөс сэргийлцгээ

Дулааны цохилт гэдэг нь, зуны улирлын өндөр температуртай, чийгшилт ихтэй нөхцөлд хүний бие дасан зохицож чадалгүй, биеийн шингэн болон давсны тэнцвэр алдагдсан байдалд орохыг хэлнэ. Толгой эргэх, толгой өвдөх, бөөлж цутгах гэх мэт шинж тэмдгүүд илэрдэг. Японд ялангуяа, борооны улирал дууссаны дараа огцом чийгтэй халуун болдог 7 дугаар сард дулааны цохилтоос улбаатайгаар эмнэлэгт яаралтай хүргэгдэх, нас барах хүн их байдаг бололтой. Та бүхэн ч гэсэн эрүүл мэнддээ анхаарал тавьж, болгоомжтой байгаарай.

◆ Дулааны цохилтоос сэргийлэхийн тулд

- ✓ Гадаа байхдаа, ус сайн шингээж авдаг, түргэн хатдаг материалтай хувцас өмсөж, халуун газраас зайлсхийх.
- ✓ Байшин барилга дотор байхдаа, сэнс болон агааржуулагч хэрэглэх, хөшгөө ашиглан халуунд өртөхөөс зайлсхийх.
- ✓ Шингэн нөхөхдөө, нэг удаад их хэмжээгээр нөхөхөөсөө илүү, бага багаар ойр ойрхон нөхөх нь сайн үр дүнтэй.
- ✓ Цаг агаарын мэдээ харж, дулааны цохилтоос сэргийлэх арга хэмжээ авах. Цаг уурын агентлагаас, хамгийн дээд температур нь 35 хэмээс дээш байхаар таамаглагдсан үед “Өндөр температурын сэрэмжлүүлэг” өгөх гэх мэтээр, дулааны цохилтоос сэргийлэхэд хэрэг болох мэдээллийг цацдаг.

◆ Дулааны цохилтонд өртсөн үед илрэх шинж тэмдэг болон авах арга хэмжээ

- ✓ Толгой эргэж, булчингаар хөндүүрлэн, булчин зангирч (шөрмөс татах), маш их хөлөрч байгаа тохиолдолд, сэрүүн газарт шилжиж, хувцсаа суллан, биеийнхээ халууныг гадагшлуулж, биеэ хөргөнө. Ус болон спорт ундаа зэргийг ууж, шингэнээ нөхнө.
- ✓ Толгой өвдөж, бөөлж цутган, бие сульдсан байгаа тохиолдолд, яаралтай тусламж дуудах зэргээр цаг алдалгүйгээр эмнэлэгт үзүүлнэ.

Мангагаар дамжуулан мэдэж авцгаая, Япон хүний сэтгэл

— Он тооллын нэр их зүйлийг хүүрнэдэг —



Аргагүй л 3 он тооллын нэр дамнасан ээж.

Японд, он тооллын нэр болон тухайн цаг үед халуун байсан дуу хөгжим, гоёлын загвар, кино, гэйм, хүүхэлдэйн кино, манга гэх мэт зүйлс, болсон явдлын дурсамж нь хоорондоо холбоотой байдаг хүмүүс олон байдаг. Рэйва ямар цаг үе болох бол? Та бүхний хүн нэг бүрийн хувьд хүсэл тэмүүллээр дүүрэн бялхан цаг үе болоосой гэж хүсэн ерөөе.



Bảng 50 âm là bảng sắp xếp cách phát âm những chữ cái trong tiếng Nhật. Mặc dù gọi là Bảng 50 âm nhưng thực ra không phải có tất cả 50 âm. Những chữ cái cổ như 「ゐ」「ゑ」 được sắp xếp lại cho ứng với cách phát âm 「い」 và 「え」 trong hàng chữ 「ア」. Chữ 「を」 trước kia được ghi âm là 「ウオ」 nhưng giờ được thống nhất lại phát âm giống như chữ 「お」, chỉ được dùng khi viết 「〇を」.

(意思) 下周去河原郊游 盼望已久 玩些什么呢
五十音图是将日语发音整理做成的表。虽然叫“五十音”，但并没有五十个发音。以前表中有的“ゐ”“ゑ”2个文字与发音和ア行的“い”“え”统一合并了。“を”以前发成类似“ウオ”的音，后来变成和“お”发音相同的“オ”，作为文字使用时，只在写「〇を」时使用。

(ibig sabihin) Sa isang linggo ay may excursion kami sa Fujiwara. Hindi na ako makapaghintay. Ano kaya lalaruin natin?
Ang Japanese syllabary chart (goju-on chart) ay isang table chart na ginawa sa pamamagitan ng pagbigkas ng Japanese. Walang limampu (goju) kahit sinasabing "limampung tunog"(goju-on). Ang mga titik at tunog ng mga salitang "ゐ" at "ゑ" na natagpuan sa lumang talahanayan ay pinag-isa sa linya na "い" at "え". Sinasabing ang "を" ay binibigkas na "ウオ"(wo) noong araw at tulad ng "お" na naging "オ", ngayon ay ginagamit na lamang bilang character ang "〇を" sa pagsusulat.

Artinya : Minggu depan kita pergi tamasya sekolah. Mau cepat pergi ya. Kita main apa ya?
Gambar susunan 50 bunyi (gojuon-zu) adalah tabel yang menata bunyi huruf bahasa Jepang. Tabel tersebut bernama 50 bunyi, tetapi tidak mengandung 50 bunyi. "ゐ" dan "ゑ", yakni huruf dan bunyi yang dulu termasuk dalam tabel tersebut, telah disatukan dengan "い" dan "え" dalam baris A. Dahulu kala, "を" berbunyi seperti "WO", tetapi sekarang telah menjadi "O" yang sama dengan "お". Saat ini, "を" tersebut hanya digunakan untuk kalimat seperti "〇を".

ตารางห้าสิบเสียงเป็นตารางที่ทำขึ้นเพื่อจัดเรียงการออกเสียงในภาษาญี่ปุ่น แม้จะเรียกว่า “โกะจูอง” หรือห้าสิบเสียง แต่ก็ได้ไม่ได้มีถึงห้าสิบเสียง ตัวอักษรและเสียงที่เมื่อก่อนเคยมีอยู่ในตารางอาทิ 「ゐ」 และ 「ゑ」 นั้น ถูกนำไปไปรวมเข้ากับเสียง 「い」 「え」 ในแถว อะ ส่วน 「を」 นั้น กล้าว่ากันว่า สมัยก่อนออกเสียงว่า “โวะ” แต่ก็กลายมาเป็นเสียง “โอะ” เหมือนกับตัวอักษร 「お」 ส่วนการเขียนก็จะเขียนไว้หลังกรรม 「〇を」 เท่านั้น

(អត្ថន័យ) នៅសប្តាហ៍ក្រោយគឺដំណើរការទៅធ្វើទេសចរណ៍ ទន្ទឹមនឹងចំណាស់ តើយើងនឹងលេងអ្វីទៅ
តារាងប្តូរសំឡេង គឺជាតារាងដែលបានធ្វើឡើងដោយរៀបចំតាមការបញ្ចេញសំឡេងរបស់ភាសាជប៉ុន។ តេហៅថា តារាងប្តូរសំឡេង (មានន័យថា សំឡេង៥០) ក៏ពិតមែន តែមិនមែនមាន ៥០សំឡេងទេ។ អក្សរនិងសំឡេងនៃ 「ゐ」 និង 「ゑ」 នៅក្នុងតារាងចាស់ត្រូវបានបង្រួមជាមួយ 「い」 និង 「え」 នៃជួរអក្សរ「ア」ជាប្តូរណាស់មកហើយ 「お」 មានសំឡេងដូចជា 「ウオ」 ប៉ុន្តែវាបានក្លាយជាសំឡេង 「オ」 វិញ គឺដូចគ្នានឹងសំឡេង 「お」 ដែរ ហើយការប្រើអក្សរវិញ គឺគេសរសេរតែនៅពេល 「〇を」 តែប៉ុណ្ណោះ។

(အဓိပ္ပာယ်) နောက်အပတ်မှာ မြစ်ကမ်းပါးမှာ ပျော်ပွဲစား မျှော်ရတာလဲ မောလှပြီ ဘယ်လိုကစားကြမလဲ
"အသံ ၅၀ ဇယား"ဟာ ဂျပန်ဘာသာအသံထွက်ကို ဇယားဖွဲ့ထားတာပါ။ အသံ ၅၀ဆိုမယ့် ၅၀ မရှိတော့ပါဘူး။ ရှေးကဇယားမှာပါတဲ့ 「ゐ」「ゑ」 ဆိုတဲ့ စာလုံးနဲ့ အသံတွေဟာ "အ" အတန်းက 「い」「え」 တွေနဲ့ ပေါင်းသွားပါတယ်။ 「を」 ကို ရှေးက "ဝို" လို့ အသံထွက်ခဲ့တယ်ဆိုပေမဲ့ အခုအခါ 「お」 နဲ့ အတူတူ "အို" ဖြစ်လာပြီး စာလုံးကိုလည်း 「〇を」 လို့ ရေးတဲ့ အချိန်မှာပဲ သုံးပါတော့တယ်။

(Утга) Дараа долоо хоногт гол руу экскурст явна. Тэсэн ядан хүлээж байна аа, тийм ээ. Юу хийж тоглох вэ?
50 авианы хүснэгт (Япон үсгийн цагаан толгой) нь, Япон хэлний дуудлагыг цэгцлэн, боловсруулсан хүснэгт юм. "50 авиа"-ны гэсэн нэртэй боловч, авиа нь 50 хүрэхгүй. Эрт үеийн хүснэгтэнд байсан "ゐ", "ゑ" гэсэн үсэг, авиа нь "ア" буюу "А"-гийн багананы "い", "え" болж нэгтгэгдсэн. "を" нь, бөгөөд бүр эрт үед бол "Во" шиг авиа байсан гэж яригддаг боловч, "お" -той ижил "О" болж, хэрэглэхдээ зөвхөн "〇を" гэж бичих үед л хэрэглэгдэх болсон.

(Meaning) We will go on an excursion to the river next week We can hardly wait What shall we do there?
The Japanese syllabary chart, called gojuonzu, systematically shows the pronunciation of the Japanese syllables. Gojuonzu literally means "fifty sounds chart," but the chart does not actually include fifty sounds. This is because the characters and syllables "ゐ" and "ゑ" that were originally in the "や" column were integrated with the characters and syllables "い" and "え" in the "あ" column, and so they became obsolete. It is said that "を" used to be pronounced "wo," but it came to be pronounced "o," which is the same as "お." Today, the "を" syllable is used only in the form of "〇を."

技能実習生・研修生向け母国語情報誌
技能実習生の友
 2019年7月 夏季号
 2019年7月1日発行
 冊子版バックナンバー：https://www.jitco.or.jp/ja/tomo/

発行 公益財団法人 国際研修協力機構 (JITCO)
 総務部広報室
 〒108-0023
 東京都港区芝浦2-11-5
 五十嵐ビルディング
 電話 03-4306-1166 (ダイヤルイン)
 JITCO ホームページ：https://www.jitco.or.jp/